



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 02-дээр

Дугаар 1/154

Арвайхээр

### Хичээл сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн "Түр журам батлах тухай" 18 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн "Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай" A/120 дугаар тушаалын 4 дэх хэсэг, 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн A/58 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах түр журам"-ын 2.2.2, аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн "Бүх нийтийн бэлэн байдлын улаан түвшинд шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" A/151 дүгээр захирамжийн 7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр, Хархорин, Хужирт, Бүрд sumaас бусад сумдын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн танхимын хичээл, сургалтыг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 оны A/491 дүгээр тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөгөөр (биений тамир, хөгжимиийн хичээлээс бусад) зохион байгуулсугай.

2. Хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 сарын 22-ны өдрийн 18 дугаар тушаалаар баталсан "Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ын хэрэгжилтийг хангах, хичээлийн байр, дотуур байрны орчинд ариутгал, халдвартайжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмж, чиглэлийн дагуу чанартай зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга, сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100334